



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Оршил

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Их хуралд хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хүлээх хариуцлага, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд аудитын үйл ажиллагаа, үр дүнд нь иргэдийн эрх ашигт нийцсэн байх зарчмыг удирдлага болгон улс, нийтийн хөрөнгийн захиран зарцуулалт, үр дүнг хянаж, үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Энэхүү аудитыг гүйцэтгэхэд дэмжиж болон хамтран ажилласан шалгагдагч, хамрагдагч байгууллагуудад талархал илэрхийлж байна.

Аудитын хураангуй тайлан бэлтгэсэн үндэслэл

Төрийн аудитын байгууллага хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод байх, төрийн аудитыг олон улсын нийтлэг стандартад нийцүүлсэн байх зарчмыг баримтлан ажилладаг.

Төрийн аудитын үнэ цэн, үр өгөөжийг нэмэгдүүлэх төрийн байгууллагуудын хариуцлагатай байдлыг дэмжиж, цаг зав багатай хэрэглэгч, харилцагч тал, иргэд олон нийтийг аудитын дүнгийн мэдээллээр хангах зорилгоор аудитын бүрэн тайланд үндэслэж энэхүү хураангуй тайланг бэлтгэв.

Аудитын харилцан хамаарал

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго, хамарсан хүрээ

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхэд ээлтэй байж чадсан эсэх;
3. Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр шинэчлэн баталж, холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулан 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн бөгөөд аудитын хамрах хүрээнд 2019-2023 оныг хамруулж байгаа тул 2016 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийг шалгуур болгосон. Гэхдээ 2024 оны 01 дүгээр 17-ны өдөр баталсан Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан эсэхийг анхаарч холбогдох байгууллагад санал хүргүүлнэ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд

- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц;
- Монгол Улсын Үндсэн хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл;
- НҮБ болон Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмж

1. Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын асуудлыг хамарсан, цогц уялдаа холбоо бүхий төрийн бодлого, үр дүнтэй тогтолцоог төлөвшүүлэх, сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улс 2016 оноос өмнө үндэсний хэмжээнд хүүхэд хамгааллын нэгдсэн бодлого, төлөвлөгөө, засаглалын тогтолцоо байхгүй байсан ба хүүхэд хамгааллын үйлчилгээг нэвтрүүлж, хэрэгжүүлэх, тайлбарлан таниулах бэлтгэгдсэн боловсон хүчин хүний нөөц хангалтгүй, хүүхдийн эрхийг хангах талаар үр дүнтэй арга хэмжээ байхгүй байжээ.

Тэгвэл 1990 онд НҮБ-ын ХЭК-д нэгдэн орсноор 2016 оноос Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль /2016 оны/, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль зэрэг олон хууль тогтоомжоор эрх зүйн орчныг бий болгож, хүүхдийн тусламжийн утас, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн эрхийн улсын байшаагч зэрэг үйлчилгээ үзүүлэгч талуудаар дамжуулан хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоог сайжруулах нөхцөлийг бүрдүүлж ирсэн байна.

Ингэснээр хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучлах, гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, шаардлагатай тохиолдолд шүүхээр хэргийг шийдвэрлүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх, түр хамгаалах, асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх зэрэг хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хууль эрх зүйн зохицуулалттай болсон байна.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцын 19¹-р зүйлд гишүүн орны үүрэг хариуцлагыг тусгасан бол 34², 35³ дугаар зүйлд хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүний наймааны аливаа зорилго, хэлбэрээр хууль бусаар ашиглахгүй, урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээ авах тухай тусгаж 2001 онд батлан оруулсан Нэмэлт Протокол, Олон улсын хүүхдийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, нэн даруй устгах тухай 182 дугаар Конвенцод Монгол Улс тус тус нэгдэн орсноор хууль эрхзүйн хүрээгээ тодорхойлох боломжтой болсон байна.

Монгол Улсын Засгийн газар хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа хүүхдэд хуулиар олгогдсон эрхээ хамгаалуулахад чиглэсэн зорилго, зорилтыг бодлогын баримт бичгүүдэд тусгадаг ч тэдгээр нь хоорондын уялдаа холбоогүй, хүрэх түвшин тодорхойгүй, үнэлж дүгнэх аргачлалгүй, цогц бодлогогүй явж ирснийг дараах жишээ харуулж байна. Үүнд:

- НҮБ-ын ХЭК-ын хэрэгжилтийн талаар 2017 оны Монгол Улсын Засгийн газрын 5-р тайлан илтгэлтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийн 3 дахь хэсгийн “Тулгамдсан асуудлууд болон зөвлөмжүүд”-ийн 6-д Цогц бодлого ба стратеги: Урт хугацааны бодлого шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх нь ерөнхийдөө бэрхшээлтэй гэдгийг тэмдэглэхийн зэрэгцээ ХЭК-ийн бүхий л чиглэлээр хүүхэдтэй холбоотой цогц бодлого баримтлахыг тэргүүлэх зорилтоо болгохыг Хороо тус улсад зөвлөж байна. Энэхүү цогц бодлогодоо суурилан үр дүнтэй хэрэгжүүлэх алсын хараа стратегиа боловсруулах шаардлагатай юм. Боловсруулсан стратеги нь хангалттай санхүү, арга зүй, хүний нөөцөөр дэмжигдсэн байх нь зүйтэй гэжээ.
- Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын түр орлон гүйцэтгэгч нарын ЗГ-ын 2017 оны 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг 5 зорилт, 127 арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр тусган баталсан бол тус хөтөлбөр нь ЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсноор⁴ хөтөлбөрийн 5 жилийн үр дүнг бүхэлд нь үнэлж дүгнэх боломжгүй болсон байна.

¹ “бүх гишүүн улс орон эцэг эх, асран хамгаалагч, бусад хүний асран хамгаалалтад байгаа хүүхэд бүрийг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн хууль эрх зүй, захиргаа, нийгэм болон боловсролын зохистой бүх арга хэмжээг авах үүрэгтэй”

² Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд дараахь зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна:

a. хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;
b. хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих;
c. хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах.

³ Оролцогч улсууд хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр хулгайлах, худалдах буюу хил дамжуулан худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна.

⁴ 52. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоол;

Хүүхэд хамгааллын чиглэлээр дэлхийн ТХЗ нь Монгол улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт бүрэн тусгагдаагүй биелэлт хангалтгүй байна.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, Үндэсний хоол тэжээлийн хөтөлбөр зэрэг хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг хамруулсан баримт бичиг гэж үзэж болох ч “Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааны 2017-2021 оны үндэсний хөтөлбөр” хамгийн их асуудлыг хамруулсан бодлогын баримт бичиг болж байжээ.

“Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачлан 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар 17 зорилго, 169 зорилтыг баталж 2016 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газар 2018 онд Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох дэлхийн түншлэлд нэгдэж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг устгахад чиглэсэн Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-тай холбогдох бүх зорилтыг хэрэгжүүлэхээр үүрэг хүлээжээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2¹-т заасныг баримтлан ХЭК-р хүлээсэн үүргийг үндэсний онцлогт нийцүүлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан тусгасан хүүхэд хамгааллын үндэсний бодлогын баримт бичигтэй болох шаардлагатай байна.

Монгол улс тогтвортой хөгжлийн зорилтод нэгдсэн Азийн 167 орноос зорилтын хэрэгжилтээрээ 99 дугаарт жагсаж байх ба ТХЗ-ын зорилтод Хүүхэд хамгааллын талаар 10 зорилтыг тусгасан байна.

Хүүхэд хамгааллын талаар МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого «Алсын хараа-2050»-д туссан 6, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-д 7, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус тусгасан байна.

Дэлхийн ТХЗ-т туссан хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилго, зорилт хүрэх түвшин, гарах үр дүнг тооцож үр дүнд суурилсан төлөвлөгөө хөтөлбөр, стратегийг боловсруулах суурь баримт бичиг болсон байна. Харин МУ-ын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний уялдааг дараах зураглалаар харуулж байна.

¹ 5.2.2 “дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх зарчим” гэж олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу дэлхий нийтийн хөгжлийн зорилго, чиг хандлагыг үндэсний онцлогт нийцүүлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт уялдуулан тусгахыг;

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүн төвтэй, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд хэнийг ч орхихгүй байх, хүний суурь эрх, эрх чөлөөг эрхэмлэх, жендерийн мэдрэмжтэй байх зарчимд нийцсэн хүүхдийн эрх, хамгааллын бодлоготой болж МУ-ын урт, дунд богино хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөртэй болсноор хүүхэд хамгааллын тогтолтоо бэхжихээр байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Зорилт 3.1 2030 он гэхэд 100,000 амьд төрөлт тутамд эхийн эндэгдлийн түвшнийг 70-аас доош болгон бууруулах

Зорилт 3.2 2030 он гэхэд урьдчилан сэргийлэх боломжтой нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг арилгах

Зорилт 3.7 2030 он гэхэд гэр бүл төлөвлөлт, мэдээлэл, мэдлэг өгөх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг үндэсний бодлого, хөтөлбөр тусгах зорилгоор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрд хүргэх

Зорилт 4.a Хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендерийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах

Зорилт 5.1 Бүх эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох

Зорилт 5.2 Албан болон хувийн хүрээнд бүх эмэгтэйчүүд, охидыг хүчирхийлэх, түүний дотор хүний хулгай наймаанд өртөх, бэлгийн болон бусад хэлбэрээр дарлах мөлжих явдлыг таслан зогсоох

Зорилт 5.3 Хүүхэд байхад нь, эрт үед, хүчээр гэрлүүлэх, эм бэлэг эрхтнийг нь зэрэмдэглэх зэрэг бүх хор уршигтай зан заншлыг таслан зогсоох

Зорилт 8.7 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэлээр шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авч, албадан хөдөлмөр хийлгэх явдлыг арилгаж, бүх хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийг цэрэг болгон элсүүлэх, ашиглах явдлыг 2025 он гэхэд эцэс болгох

Зорилт 16.1 Хүчирхийллийн бүх хэлбэр, нас баралтын холбогдолтой түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулах

Зорилт 16.2 Хүүхэдтэй зэрлэгээр харьцах, тэднийг мөлжих, наймаалах, тамлан зовоох, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсоох устгах



АЛСЫН ХАРАА-2050

2.1.24. Сургуулийн дотуур байрны менежментийг сайжруулан багш нарын ажлын ачааллын 10 хүртэлх хувьд дотуур байранд сурагчдын хөгжлийг дэмжих чиглэлээр хийсэн сургалт, хөгжлийн үйл ажиллагааны цагийг тооцдог байх зохицуулалт хийж, дотуур байрны хүүхэд хамгааллыг сайжруулна.

2.2.16. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

2.3.2. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана.

7.3.6. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна.

9.1.8. Хүүхэд хамгаалах төв, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр өнжүүлэх төв, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай тохижилт үйлчилгээг хийнэ.

9.3.23. Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

2.3.1. хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.

2.3.2. хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.

2.3.5. хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно.

7.3.1. үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

7.3.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

7.3.6. иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.

9.1.1. нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.



ЗГҮАХ-Т 2020-2024

2.5.8. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.

4.3.3. Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.

4.3.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.3.5. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.

4.4.5. Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

- Агуулгын хувьд (бүрэн) уялдаж байгаа зорилт, арга хэмжээ
- Огт хэрэгжихгүй байгаа зорилт, арга хэмжээ

Засаглалын тогтолцог бэхжүүлж, хамтарсан багийн ажлын уялдааг хангах нарийвчилсан төлөвлөгөө шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 48 дугаар захирамжаар ХТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг бүх яамдын дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар, Олон улсын байгууллагын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдээс нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулан бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүргийг хүлээжээ.

Үүнээс хойш Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд 2022 оны 23 дугаар захирамж, 350 дугаар тогтоол, 2023 оны 352 дугаар тогтоолоор тус тус 3 удаа бүтцэд өөрчлөлт орж, 2018, 2023 онд дүрэмд өөрчлөлт орсон байна.

ХТҮЗ нь 2018 онд 1 удаа хуралдаж 01 дүгээр тогтоолоор зөвлөлийн дүрэм, 02 дугаар тогтоолоор үйл ажиллагааны төлөвлөгөө, 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” хүүхэд хамгааллын жишиг баримт бичгийг тус тус баталсан байна.

“Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” хүүхэд хамгааллын жишиг баримт бичиг нь байгууллага, эцэг, эх албан хаагчдаар дамжуулан хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалтыг хангуулахад чиглэсэн боловч салбарын тогтолцоог сайжруулах, хүүхэд хамгаалагдахад үр дүнгээ өгсөн баримт бичиг гэж үзэхээргүй байна.

Харин 2019, 2022 онд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бол 2020, 2021 онд баталж хэрэгжүүлсэн төлөвлөгөөгүй байна.

Хүснэгт 1: Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан зорилт

	Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө			
	2019 он		2022 он	
	Тоо	%	Тоо	%
Хүүхэд хамгааллын чиглэлээр	12	24%	5	18%
Хүүхдийн эрх, оролцоог хангах чиглэлээр	7	15%	3	11%
Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах	30	61%	20	71%
Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	48.7%		89.6%	

Эх сурвалж : ХТҮЗ-ийн Батлагдсан төлөвлөгөө тайлан.

ХТҮЗ-ийн баталсан 2019, 2020, 2022 оны төлөвлөгөө нь төрийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны 66%-ийн давхцалтай байгаа нь хүүхэд хамгааллын салбарт хангалттай анхаарч ажиллахгүй, жилд нэгээс хоёр удаа хуралдаж тухайн жилийн төлөвлөгөө тайлан мэдээтэй танилцах хэлбэрээр ажиллаж байгаа нь салбар дундын зохицуулалт хийж ажиллах үүргийн биелэлт хангалттай хэрэгжихгүй байна.

2. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн болон хүний нөөцийг оновчтой төлөвлөж, зарцуулах шаардлагатай байна.

Санхүүгийн нөөцийг судалгаа, статистик тоо мэдээлэлд үндэслэн төлөвлөж чадахгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль /2016 оны/-ийн 2 дугаар зүйлийн 2.2¹-д Нийгмийн бүх орчинд хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх олон талт, цогц мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэх тухай тодорхойлж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1²-д Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын үндэсний болон орон нутгийн тогтолцоог удирдан зохион байгуулж явуулах үйл ажиллагааны чиглэлийг тусгасан байна

¹ Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

² Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь үйл ажиллагаа явуулах замаар хүүхэд хамгааллын үндэсний болон орон нутгийн тогтолцоог удирдан зохион байгуулна

ХНХ /хуучин нэрээр/-ын сайдын 2021 оны А/209 дүгээр тушаалаар “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам”, 2021 оны А/210 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”, 2021 оны А/218 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны А/23, А/27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, зардлын норматив”-ыг баталж хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх эрх зүйн орчин бий болсон байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг 2019-2021 он хүртэл зардлын нэг ангиллаар төлөвлөж, баталж байсан бол 2023 оны төсвийн саналыг 2019 оны холбогдох статистик тоон мэдээнд тулгуурлан боловсруулсан байна.

Монгол улсын хэмжээнд 2019-2023 оны байдлаар улсын төсвөөс хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд 40,123.3 сая төгрөг төсөвлөж батлагдсанаас 37,624.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна

Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 онд хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын Засгийн газар уг хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хуваарилалтыг нэмэгдүүлж 2017 оноос хойш хүүхэд хамгааллын үйлчилгээний зориулалттай улсын төсөв тасралтгүй нэмэгдэж 2023 оны байдлаар 8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ХГБХХЕГ нь нийслэл, орон нутгийн үйл ажиллагааны болон хүүхэд хамгааллын төсвийн саналыг хүлээн авч нэгтгэн хүргүүлж батлуулдаг ч батлагдсан төсөв харилцан адилгүй байна.

Дүрслэл 1. Төсвийн санал, батлагдсан төсөв, ангиллаар



Хүүхэд хамгаалах үйлчилгээний төсвийн төсөлд дараах 34 байгууллага хүүхэд хамгааллын зардлыг нэгтгэн тусгадаг байна. Үүнд:

- Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газар /ХГБХХЕГ/
- Нийслэл дэх ХГБХХГ,
- 9 дүүргийн ХГБХХГ
- Орон нутгийн ХГБХХГ-21
- Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр

Хүснэгт 2. 2023 оны орон нутгийн хүүхэд хамгааллын төсвийн санал, батлагдсан төсвийн харьцуулалт /түүвэрлэн харьцуулав/

Аймаг нэр /ХГБХХГ/	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо /2022он/	Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ авсан хүүхдийн тоо /2022 он/	Хамтарсан багийн тоо /2022/	Төсвийн саналын дүн /мянган төгрөг/	Батлагдсан төсөв /мянган төгрөг/	Төсвийн саналын өөрчлөлт %-р
Архангай	156	16	26	94.2	108.1	14.8
Баян-Өлгий	200	28	27	147.5	111.1	-24.7
Баянхонгор	2184	53	30	427.2	398.0	-6.8
Говь-Алтай	390	17	30	109.9	109.3	0.6
Дундговь	1606	-	15	60.2	152.1	152.7
Өмнөговь	198	142	22	93.5	233.6	149.7
Хэнтий	227	63	14	122.2	261.4	113.9
Говь сүмбэр	195	28	3	32.7	74.1	126.7

Эх сурвалж ХГБХХЕГ

Хохирогч хүүхэд түр хамгаалах, нэг цэгийн үйлчилгээний төвийн байранд байрлуулж шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг ч дахин хүчирхийлэлд өртөн ирдэг байна. Жишээ нь: 2023 онд 3308 хүүхэд тусламж үйлчилгээ үзүүлснээс 275 хүүхэд 2 удаа, 132 хүүхэд 3 удаа, 116 хүүхэд 4 ба түүнээс дээш удаа байрлан үйлчилгээ авсан байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулагдаж байгаа санхүүжилтийн багагүй хувь нь түр хамгаалах, нэг цэгийн байранд байрлуулж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах нэг хүнд ногдох хувьсах зардал эзэлдэг байна.

Хүснэгт 3 Хүүхэд хохирсон хүчирхийллийн хэлбэрүүд

Он	Нийт хүүхэд	Үүнээс				
		Бие махбодын хүчирхийлэл	Сэтгэл санааны хүчирхийлэл	Бэлгийн хүчирхийлэл	Үл хайхрах хүчирхийлэл	Бусад
2019	2020	307	362	169	758	424
2020	2179	461	360	151	895	312
2021	2916	400	592	277	1477	567
2022	3995	579	963	343	1481	629
2023	3308	423	615	338	1412	689

Улсын хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг олж илрүүлэх, түүнд зарцуулах санхүүжилт харилцан адилгүй байх бөгөөд хүүхдийн тоо мэдээ зөрүүтэй байгаагаас санхүүжилтийг хуваарилах асуудал анхаарах шаардлагатай байна.

Хүснэгт 4 Хүүхэд хамгааллын 2019-2023 онд эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал. Сая төгрөг

Хүүхэд хамгааллын эрсдэлийн болон НБҮ хийх зардал					
Байгууллагын нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
ЗГХА ГБХЗХГ	-	-	143.0	-	-
ХТУ-108 үйлчилгээний төв	-	-	-	34.6	24.2
21 аймаг	207.6	188.8	94.1	152.5	116.5
Нийслэлийн ГБХЗХГ	130.9	61.2	115.3	280.3	181.2
Нийт	338.5	249.9	352.5	467.5	321.9

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/33 тушаалаар “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан бөгөөд 9 дүгээр зүйлийн 9.2-д “Асрамж халамжийн байгууллагын хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хоол хүнс, хувцас, эм, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэгдэхүүний зардлыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5.1¹-т заасны дагуу тооцож нийгмийн халамжийн сангаас олгоно” гэж тусгажээ.

Хүүхэд хамгааллын 2019-2023 онд батлагдсан төсвийн 9 хувийг хүүхэд хамгааллын нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээ ТББ-д гэрээлэн гүйцэтгэсний зардалд олгосон байна.

Мөн Зардлын нормативыг 2022 оны үнийн индекстэй уялдуулж баталснаас хойш 2024 оныг хүртэл жил жилийн үнийн өсөлттэй холбогдуулж өөрчлөлт хийгээгүй байна. Үүнээс шалтгаалж төрийн бус байгууллагуудын үйлчилгээ, үйл ажиллагаа чанар стандартад нийцэхгүй, тогтворгүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ дэмжигдэхгүй байна.

ХГБХХЕГ-нь ТББ-тай байгуулсан гэрээний гүйцэтгэл, үр дүнг тооцож дүгнэдэггүй бөгөөд гэрээгээр гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээний талаар олон нийтэд ил тод нээлттэй мэдээлдэггүй нь нийгэмд хардлага төрүүлэх суурь шалтгаан болж байна.

“Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-д шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх гэсэн ангиллаар санхүүжүүлэх зохицуулалттай байна.

ХГБХХЕГ нь 2022-2023 онд хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээнд 3,085.8 сая төгрөгийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд тусган 2,092.8 сая төгрөг буюу 67.8%-ийг хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд, 993.0 сая төгрөг буюу 32.2%-ийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

¹ хоол хүнс, хувцас, эм, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэгдэхүүний нэг хүнд ногдох зардлын норматив, эдэлгээний хугацаа;

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулсан зардлыг шалгахад ХГБХХЕГ нь 2022, 2023 онд 158.9 сая төгрөг, аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 1,906.1 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж хүний болон санхүүгийн оновчтой төлөвлөлтөөс шууд хамааралтай байхаар байна.

Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ.



Монгол улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 0-18 насны 1,260,700 орчим хүүхэд байгаагаас 49 хувь нь нийслэлд амьдарч байна.



Дээрх зардлыг “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний норматив”-аар тооцоход

Бие махбодын хүчирхийлэлд **257,340**

Бэлгийн хүчирхийлэлд

4,760,799

Сэтгэл санааны хүчирхийлэлд

287,340

Үл хайхрах хүчирхийлэлд

81,439 төгрөгөөр тооцож хамгаалах,

нөхөн сэргээх үйлчилгээг нэг

хүүхдэд дунджаар 1,346,729


төгрөгийн үйлчилгээ авахаар байна.

Энэ нь 2019-2023 онд хүүхэд хамгааллын төсвөөс зориулалт бус зарцуулсан **3,007,960,000** төгрөгөөр **2233** хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх боломжтой байжээ.


2020-2023 оны хүүхэд хамгааллын салбарын хүний нөөцийг төсөвтэй харьцуулан үзэхэд жил бүр хүний нөөц болон түүнтэй холбогдох зардал өссөн боловч хүүхдийн хүчирхийллийн кейс шийдвэрлэлт хангалтгүй байна.

Дүрслэл 2 Нийт хүүхдийн тоо


Нийт төсөв



Нийт хүүхдийн тоо



Дүрслэл 3 2023 оны аймаг, нийслэлийн хүүхэд хамгааллын төсөв, үйлчилгээний харьцуулалт



Эх үүсвэр: ХГБХХЕГ

Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэшсэн боловсон хүчний хүрэлцээ тогтолцоог сайжруулах түвшинд байна.

Нийгмийн хамгааллын тухай багц хууль 2016 онд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, ачаалал нэмэгдсэн ч албан хаагчдын орон тоо хүрэлцээгүй хэвээр байна.

ХГБХХЕГ нь 2019 оноос 2023 он хүртэл 50 хүрэхгүй орон тоотой, аймаг, нийслэлд дунджаар 15-аас 30 албан хаагчтай төрийн захиргааны байгууллагын бүтэц ажиллаж жил ирэх тусам хүний нөөц нэмэгдэж байгаа ч хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар мэргэшсэн албан хаагч дутмаг хэвээр байна.

Хүснэгт 5 Батлагдсан орон тоонд эзлэх албан хаагчдын бүтэц

Ангилал	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Батлагдсан орон тоо	996	1020	1100	1145	1112
Ажиллаж байгаа орон тоо	944	980	1016	1033	999
Үүнээс нийгмийн ажилтан	113	126	146	145	154
Сэтгэл зүйч	46	47	50	48	50
Бусад	622	647	694	701	707

Эх сурвалж: ГБХНХЯ, ХГБХХЕГ-ын хүний нөөцийн судалгаа

Дээрх хүснэгтээс нийт ажилтны 32.3 хувь нь үндсэн чиг үүрэг хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх сэтгэл зүйч, нийгмийн ажилтан байгаа бол 67.7 хувь нь байгууллагын үйл ажиллагааг хариуцсан, дэмжлэг үзүүлэх захиргаа, санхүү, бусад үйлчилгээний ажилтнууд байгаа нь хүүхэд хамгааллын салбар нь хүний нөөцийн бодлогод дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14.3-т заасны дагуу гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Сургалт, судалгаа, мэдээллийн төвтэй байх бөгөөд тус төв хүүхэд, гэр бүлийн асуудлаар үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлтөд зориулсан судалгаа, үүрэг хүлээгч талуудад тогтмол сургалт, мэдээлэл өгч ажиллах чиг үүрэгтэй. Гэтэл тус төв нь хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр судалгаа, сургалт, мэдээллийг тогтмол, үр дүнтэй хийж хэвшээгүй байна.

Олон Улсын байгууллагын санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд хүүхэд хамгааллын тогтолцооны чадавхыг бэхжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа ч орон нутгийн хамтарсан баг, ХЭХЗХ, ХТЗ, аймаг, нийслэлийн анхан шатны нэгжид төдийлөн хүрч ажиллаж чаддаггүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3¹ дах хэсэгт хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь мэргэшсэн хүний нөөцтэй байхаар заасан байгаа боловч жил бүр тухайн салбарын гурван ажилтан бүрийн нэг нь чөлөөлөгдөж, томилогдож байгаа нь хүний нөөцийн тогтворгүй байдлыг харуулж байна.

Хүснэгт 6 Хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөний мэдээлэл

Он	Батлагдсан орон тоо	Ажилласан дундаж жил /Нийт ажилласан жил/				Тухайн жилд томилогдсон, чөлөөлөгдсөн тухай мэдээлэл		Тухайн жилд томилогдсон, чөлөөлөгдсөн албан хаагчдын тоог батлагдсан орон тоотой харьцуулсан мэдээлэл		
		1 жил хүртэл	2-3 жил	4-5 жил	5-аас дээш жил	Шинээр томилогдсон	Чөлөөлөгдсөн	Томилогдсон хувиар	Чөлөөлөгдсөн хувиар	Дундаж хувь
2019	996	250	172	122	413	345	280	34.6%	28%	31.3%
2020	1,020	235	199	152	393	387	288	37.9%	28.2%	33.05%
2021	1,100	219	216	166	404	370	295	33.6%	26.8%	30.2%
2022	1,145	203	183	188	424	577	496	50.3%	43.3%	46.8%
2023	1,112	209	179	155	442	431	372	38.7%	33.4%	36.05%

Эх сурвалж: ГБХНХЯ, ХГБХХЕГ-ын хүний нөөцийн судалгаа

¹ Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд анхан шатны нэгжээс эхлэн бодлого тодорхойлох түвшинд мэргэшсэн хүний нөөцтэй байх шаардлагатай байгаа боловч ХГБХХЕГ-ын харьяа нийслэл, дүүрэг, аймгийн газруудын 2019-2023 оны хүний нөөцөд дүн шинжилгээ хийхэд нийт орон тооны 35.5% шилжилт хөдөлгөөнтэй байна.

Хүүхэд хамгааллын үүрэг хүлээгчид, үйлчилгээ үзүүлэгчдийн мэргэшсэн бус, хүний нөөцийн тогтворгүй байдлаас шалтгаалж хүүхэд хамгааллын тогтолцоо алдагдаж байна.

3. Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнг үнэлж, тооцох шаардлагатай байна.

Улсын хэмжээнд 108 тусламжийн утсанд ирсэн дуудлага мэдээллийг бүртгэж хянаж хэвшээгүй, баримт бүрдүүлэлт, программ ашиглалт хангалтгүй байна.

Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв” байгуулагдаж, хүүхдийн эрхийн зөрчлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага мэдээллийг 24 цагаар хүлээн авч, хүүхдийн санаа бодлыг сонсох, хүүхэд болон гэр бүлд сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг утсаар өгч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай дуудлага мэдээллийг 21 аймаг, 9 дүүргийн ХГБХХГ, хэлтэст шилжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв нь дуудлага мэдээллийг хүлээн авах, холбон зуучлах үйлчилгээг Нар болон хариу үйлчилгээний 2 программыг ашиглан гүйцэтгэж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны А/259 дугаар тушаалаар “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлага хүлээн авах, шилжүүлэх, ашиглах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Дуудлага мэдээллийн программд мэдээллийг хянах, хариу үйлчилгээг бүртгэх, мэдээллийн мөрөөр хэрхэн ажилласан, үйлчилгээний төрөл зэрэг мэдээллийг хамтарсан багийн нарийн бичиг оруулж, үйлчилгээ үзүүлж дууссан гэж үзвэл аймаг, дүүргийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн хяналт тавьж тухайн кейсийг хааж байна.

Аймаг, дүүргийн ХГБХХ-ын газар хэлтсийн 108 тусламжийн утсанд ирүүлсэн дуудлага мэдээллийн шийдвэрлэлтийг түүвэрлэн шалгахад дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

2021 онд:

- 3-5 хоногт буюу хугацаа хоцорч шилжүүлсэн дуудлага 399,
- 5-с дээш хоногт шилжүүлсэн дуудлага 2176,
- Дуудлага очсон боловч бүртгэж хүлээж аваагүй, хамтарсан багт шилжүүлээгүй 4083,

2022 онд:

- 3-5 хоногт шилжүүлсэн дуудлага 1871,
- 5-с дээш хоногт шилжүүлсэн дуудлага 1127,
- Дуудлага очсон боловч бүртгэж хүлээж аваагүй, хамтарсан багт шилжүүлээгүй 2487,

2023 онд:

- 3-5 хоногт буюу хугацаа хоцорч шилжүүлсэн дуудлага 1571,
- 5-с дээш хоногт шилжүүлсэн дуудлага 4490,
- Дуудлага очсон боловч бүртгэж хүлээж аваагүй, хамтарсан багт шилжүүлээгүй 1383 дуудлага байна.

Хүүхдийн тусламжийн 108 үйлчилгээний төвд ирсэн дуудлага, мэдээллийг харьяаллын дагуу нийслэл, дүүрэг, 21 аймгийн гэр бүл хүүхдийн асуудал хариуцсан байгууллагад шилжүүлж сум, дүүрэг, баг, хорооны хамтарсан багт шилжүүлж, /журмын 4.1-4.3/ 72 цагийн дотор нөхцөл байдлын үнэлгээ хийж шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

108 дуудлагын төвд ирсэн хүүхдийн үл хайхрах, сэтгэл санааны, бие махбодын, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээллийн кейс тохиолдлоос 2019-2023 оныг хамруулан түүвэрлэн авч үзэхэд нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй, хариу арга хэмжээ аваагүй, 2-11 сарын дараа хүлээн авч хаасан зэрэг тохиолдлууд байна

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хяналт тавьж хариуцлага тооцох тогтолцооны уялдааг хангах, сайжруулах түвшинд байна.

Хүүхэд хамгааллын зөрчил, асуудлыг таних, илрүүлэх, мэдээлэх, бүртгэх, шалгах, хариу арга хэмжээ авч ажиллах үндсэн нөхцөл, түүнд хамтран ажиллах механизм, талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон Хүүхэд хамгааллын тухай хууль /2016 оны/-ийн хэрэглээ түүний үр нөлөөг үнэлэх чиг үүрэг тус хуулиар ХГБХХЕГ-т тусгагдсан байна.

Мөн Хүүхэд хамгааллын салбарын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтэд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, ГБХНХЯ, ХГБХХЕГ, болон орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл зэрэг байгууллагууд бодлогыг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна.

Хүүхдийн сайн сайхан байдал хангагдахад нийгмийн бүхий л салбарын үүрэг оролцоо чухал байна. Тэрхүү үүрэг оролцоонд тавих хяналтыг гадагш болон дотогш чиглэсэн гэж авч үзэхээр байна. Гадагш буюу нийгэмд чиглэсэн хяналт нь иргэн бүрийн үндсэн эрх үүрэгтэй хамаатуулж ойлгох, харин дотогш чиглэсэн хяналт нь хүүхдийн асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хуулиар зохицуулсан хяналт юм.

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаа, бодлого тогтолцоонд анхан шатны нэгжээс дээд шатанд хүртэл, иргэн хуулийн этгээдийн оролцоог хамруулан хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгждэггүй байна. Үүнд:

- Хамтарсан багийн гишүүд болох Засаг дарга, нийгмийн ажилтан, эмч, цагдаа тус бүр өөрийн мэргэжлийн байгууллагад харьяалагддаг бөгөөд гишүүдийн ажил үүргийн хуваарьт тус багт ажиллах тухай байхгүй, цалин урамшуулал олгогдох эсэх нь тодорхойгүйгээс хариуцлага тооцох боломжгүй.
- Хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох журмуудад анхан шатанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг тусгаагүй байна.
- Байгууллага бүр эцэг эхийн зөвлөл байгуулах тухай бодлогын баримт бичиг батлагдсан ч улсын хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгаа, үр дүн, сайжруулалт, хяналт, хариуцлагын хэлбэр зэрэг асуудал огт байхгүй.
- Улсын хэмжээнд ХТҮЗ, орон нутагт ХТЗ нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавихаар хуульд заасан ч 2019-2023 оны батлагдсан төлөвлөгөө, тайлан, хурлын тэмдэглэлд хяналт тавих шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааг үнэлэх аргачлал, хүүхэд хамгааллын салбарт хяналт хэрэгжүүлсэн тухай баримт, мэдээлэл байхгүй,
- ХЭХЗ-нь үүссэн нөхцөлд байдлыг шийдвэрлэх дээр ажилладаг ч цаашид хэрэгжүүлэх хяналтыг орхигдуулдаг,
- Хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хуульд тусгайлан заасан үйл ажиллагаанд тавих хяналтыг хуульд нийцүүлэн бүрэн гүйцэт хийдэггүй,
- Асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг гадаадын болон дотоодын ТББ-ын үйл ажиллагааны стандартад жилд 2 удаа хяналт хэрэгжүүлэхээс хүүхэд хамгаалалд чиглэсэн хяналт байхгүй
- Хүүхдийн үрчлэлт түүний мөрөөр хийгдэх хяналт байхгүй зэрэг болно
- Хүүхдийн 108 утасны мэдээллийн сангаас хаанахын хэн гэдэг хүүхэд хамгааллын ямар зөрчил, гэмт хэрэгт өртсөн, шуурхай тусламжийн ямар үйлчилгээнд холбон зуучилсныг мэдэж болох ч нөхөн сэргээх хариу үйлчилгээний үр дүнд хяналт тавьж чадахгүй байна¹.
- Хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгтэй холбоотой хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөж байгаа хүүхдийг илрүүлэх, зөрчлийг таслан зогсоох ажилд бүрэн дайчилж чадахгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт, үр дүнг харуулах боломжтой тоон мэдээллийг системтэй цуглуулсан нэгдсэн мэдээллийн сан яам, агентлаг дээр байхгүй байгаа нь хяналтын тогтолцоо бүрэн хөгжөөгүй байгааг харуулж байна.

Хамтарсан багийн гишүүд өөрийн үндсэн ажилтай хавсран, цалин урамшуулал, мэргэжил арга зүйн дэмжлэггүй хамгааллын үйлчилгээ үзүүлж ирснээс гадна хамтарсан багын ахлагч буюу засаг дарга нь улс төрөөс хараат томилгоотой, гишүүд нь ажлын ачаалал их, мэргэжлийн бус байдал нь хүний нөөцийн тогтворгүй байдлыг бий болгож, төрийн үйлчилгээний залгамж халаа алдагдсанаас хамгаалал шаардлагатай хүүхдийн тоо бодитой бус зөрүүтэй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо буурахгүй, үйлчилгээний үр дүнд ахиц гарахгүй байна

Хүүхэд хамгааллын тухай хууль /2016 он/-ийн 22.1-т хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд

байгаа хүүхэд үзүүлэх хариу үйлчилгээг үнэлэх зорилгоор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 7 чиглэлээр хяналт, шинжилгээ, үнэлгээг хийхээр заасан боловч хүний болон санхүүгийн нөөцийн дутагдалтай байдлын улмаас хэрэгжүүлдэггүй гэх нийтлэг тайлбарыг ирүүлсэн байна.

Мөн ХГБХХЕГ-ийн бүтэц, чиг үүрэгт Олон Улсын болон гадаад улсын байгууллагаас Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт судалгаа хийхэд хэрхэн зөвшөөрөл олгох тухай тусгаагүй бөгөөд хэрхэн зөвшөөрөл олгох, нарийвчилсан журамгүй байгаагаас үзэхэд ХХТХ-шинэ хуулийн 47 дугаар зүйлийн 47.10 дахь заалтыг хэрэгжүүлэхэд бэлэн бус, гадаадын байгууллага хүүхдийн талаарх ямар мэдээлэл цуглуулж, тандалт судалгаа хийгдэж байгаа талаарх асуудалд хяналт тавьж чадаагүй хэвээр байх эрсдэл үүсээд байна.

Энэ нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.1.5.Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институц хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах гэж, үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах, мэдээллийн аюулгүй байдал зэрэг Аюулгүй байдлын цогц бодлоготой байх гэсэн заалттай нийцэхгүй байна.

НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенцоос Монгол Улсад өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй, Олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл хөтөлбөр, хандив тусламжийг бүртгэх, хөрөнгийн зарцуулалт, үр дүнг тооцох хяналтын тогтолцоо байхгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 5-р тайлан илтгэлтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжид нэн даруй арга хэмжээ авах хэрэгтэй дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

Төсөв нөөцийн хуваарилалт;
 Бизнесийн салбар ба хүүхдийн эрх;
 Үл ялгаварлах;
 Гэр бүлийн орчин;
 Орчны эрүүл мэнд ;
 Хүүхдийн хөдөлмөр болон унаач хүүхдийн асуудлыг багтаасан эдийн засгийн мөлжлөг.

Уг зөвлөмжийн дагуу Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл 2018 онд Хүүхэд хамгааллын талаар баримтлах бодлого чиглэлийг баталсан боловч тухайн баримт бичиг нь үндэсний хэмжээний цогц бодлого, стратегийн баримт бичиг болж чадаагүй бөгөөд өнөөгийн уялдаа холбоо хангалтгүй, нөөцийн хуваарилалт оновчгүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ хүртээмжгүй зэрэг асуудлуудын шалтгаан болж байна.

Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн хүрээнд өгсөн зөвлөмжийн биелэлт удаашралтай байгаа нь хүүхэд хамгааллын тухай бодлого болон хяналтын механизмыг сайжруулахад сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

- ХЭК-ийн бүхий л чиглэлээр хүүхэдтэй холбоотой цогц бодлого баримтлахыг тэргүүлэх зорилтоо болгохыг Хороо зөвлөсөн байна. Энэхүү цогц бодлогодоо суурилан үр дүнтэй хэрэгжүүлэх алсын хараа стратегиа боловсруулах шаардлагатай юм. Боловсруулсан стратеги нь хангалттай санхүү, арга зүй, хүний нөөцөөр дэмжигдсэн байх. Гэвч хүүхэд хамгааллын цогц бодлого боловсруулж, батлаагүй бөгөөд тус зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.
- Мэдээлэл цуглуулах тогтолцоогоо аль болох яаралтайгаар үр дүнтэйгээр сайжруулах. Бүх хүүхдийн нөхцөл байдал, нэн ялангуяа эмзэг байдлын нэн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн талаар дүгнэлт шинжилгээг сайжруулахын тулд Конвенцын бүх хүрээг хамруулан хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил, яс үндэс, нийгэм-эдийн засгийн байдал зэрэг дэлгэрэнгүй байдлаар мэдээллийг цуглуулах. Гэвч мэдээллийн нэгдсэн сан үүсгээгүй;
- Тухайн асуудлаар ажилладаг яамд мэдээллийн өгөгдөл болон шалгуур үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар ашигладаг, тэдгээрийг Конвенцыг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого, шийдвэр, төсөл хөтөлбөрийг боловсруулах, хяналт, үнэлгээ хийхдээ ашигладаг байхад анхаарах (10 б) ;
- Унаач хүүхдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, бие махбодын шийтгэл, хүүхэд асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэгчдэд мониторинг хийх, тэдний үйл ажиллагааг зохицуулах, төрсний гэрчилгээний олголт зэрэг асуудлаар Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх (10 с).

Олон улсын гэрээний хэрэгжилтэд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3-р зүйл², Олон улсын гэрээний тухай хуулийн 24.5³, Яамдын эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.10⁴ -т зааснаар ГБХНХЯ хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. Гэвч Олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болон санхүүгийн зарцуулалтад хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, үр дүнг, эерэг өөрчлөлтийг тооцож ажилладаггүй байна.

Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт, судалгаа хийхийг хориглоно гэсэн үндэсний бодлого алдагдсан байна.

Өнөөдрийн байдлаар 15 орчим Олон улсын байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар судалгаа хийх, хандив тусламж өгөх, тайлан мэдээлэл гаргах зэрэг ажилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Улсын хэмжээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжил чиглэлээр өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж хүүхдийн эрх хамгаалал, хүүхдийн хөгжилд чиглэсэн хандив тусламж, дэмжлэг, сургалт судалгаа зэрэгт ихээхэн санхүүжилт зарцуулаг тухай тухайн байгууллагын тайлан мэдээллээс харж болох юм.

Жишээ дурдахад Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын сүүлийн 3 жилд жил бүр 2-3 сая ам.доллар буюу жилд дунджаар 6.5 тэрбум төгрөгийг хүүхэд хамгаалалд, харин 9 тэрбум төгрөгийг хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт зориулан зарцуулсан нь нийт дүнгээрээ хүүхэд хамгаалалд зарцуулж буй улсын төсвөөс 2 дахин өндөр байгааг тайланд дурдсан байна.

Олон Улсын байгууллагаас Засгийн газартай гэрээ байгуулан төслийн мэдээллийг Сангийн яамнаас авч танилцахад Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2019-2024 оны хугацаанд “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийг онд хэрэгжүүлсэн ч төслийн үр дүнг тооцож үнэлсэн тухай баримт, мэдээлэлгүй байна.

Гэвч хүүхэд хамгааллын салбарт хэрэгжүүлсэн ОУ-ын байгууллагын үйл ажиллагаа, төслийн мэдээлэл, хандив, тусламж, дэмжлэгт зарцуулсан санхүүжилт үр дүнг нэгтгэх, бүртгэх тогтолцоо байхгүй, тухайн салбарт нэмэгдүүлсэн эерэг өөрчлөлтийг тооцож, хяналт тавьж ажилладаггүй байна.

Цаашид олон улсын байгууллагатай хамтран ажиллах, санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах, үр дүнг тооцох, хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хүүхдийн оролцоо нийгэмшүүлэх тогтолцоо сайжруулах түвшинд байна.

Хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн оролцоог бодитой хангах механизм, мэдлэг, чадвар, дутагдаж хүүхэдтэй холбоотой шийдвэрийг насанд хүрэгчид, үйлчилгээ үзүүлэгчид өмнөөс нь гарган хүүхдийн дээд эрх ашгийг хангаж чадахгүй байна. Цаашид хүүхдийн оролцоог бодитой болгох, хүүхдүүдэд амьдрах үр ухаан, зөөлөн чадвар, даван туулах чадавхыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тэгш, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна.

НҮБ-ын ХЭЖ-ийн 12 дугаар зүйлийн 1-д “Оролцогч улсууд өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө” гэж тусгасан ч хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн оролцоог хангахад аймаг, нийслэл улсын хэмжээнд хүүхдийн чуулган нэртэй арга хэмжээ зохион байгуулах төдийд хэрэгжиж байна.Тухайлбал:

- “Хүүхдийн оролцооны үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар 2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан болон Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээтэй хамтран Төрийн ордонд зохион байгуулсан,
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газраас “Бид оролцье, хөгжье” Хүүхдийн үндэсний чуулган, “Хүүхдийн эрх, хамгаалалд үүрэг хүлээгчдийн хариуцлага” улсын зөвлөгөөнийг 2013 онд зохион байгуулсан,
- Монголын хүүхдийн чуулганыг 2012 онд Олон улсын Хүүхдийн “Найрамдал” төвд аймаг, нийслэлд оршин суудаг 11, 15, 18 насны эрэгтэй, эмэгтэй хүүхдийг хамруулан зохион байгуулсан
- Хүүхдийн цэнгээнт болон бусад нэвтрүүлэгт оролцуулах гэх мэт.

² Оролцогч улсууд хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, алба, байгууллагыг аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарт, ялангуяа ажилчдын орон тоо, чадавхид хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас тогтоосон жишигт нийцсэн нөхцлөөр хангана.

³ Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаад тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

⁴ Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, тэдгээрт хууль тогтоомжийг нийцүүлж, биелэлтийг хангуулах;

Өнөөгийн хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн оролцоо хамгийн сул салбаруудын нэг байгаа бөгөөд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа төлөвлөх, төсөвлөхөд хүүхдийг огт оролцуулдаггүй.

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн өмнөөс хамтарсан баг, хамгаалах байр, НЦҮТ, багш, цагдаа зэрэг үйлчилгээ үзүүлэгч талууд шийдвэр гаргаж байгаа нь хүүхдийн үзэл бодлыг сонсох, насанд нь тохирсон шийдвэр гаргах нөхцөл боломжоор хангах талаар наад захын ойлголт мэдлэг байхгүйтэй нь холбоотой юм. Зарим аймаг, дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлд хүүхдийн төлөөллийг оруулж байгаа нь зөвхөн бэлэг тэмдэг төдий байдлаар байлгаж байна.

Гэр бүл⁵, сургуулийн орчинд хүүхэд өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх, өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох боломж, нөхцөл байхгүйгээс хүүхдийг оролцоог хангах дадал нийгмийн аль ч орчинд бэхжээгүй байна.

Олон нийт, иргэдийн оролцоог хангуулахаар бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжийг “Хүүхэд хамгааллын бодлого”-той ажиллахыг ХТҮЗ-өөс уриалж 2018 онд байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг болон байгууллагын эцэг эхийн зөвлөлийн зөвлөмжийг баталж 2018 оноос хойш ХНХЯ, ГБХЗХГ /хуучин нэрээр/ хамтран төрийн захиргааны байгууллагуудад сургалт, сурталчилгаа хийх замаар бусад байгууллагад түгээснээр хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг иргэд олон нийтэд таниулах ажлын эхлэл болжээ. Тухайлбал:

- Хэнтий аймагт 58 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулж, Хүүхэд хамгааллын бодлогоо хэрэгжүүлдэг болжээ.
- Дундговь аймагт 117 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулж, Аймгийн ХГБХХГ-аас 187 зөвлөлийн гишүүнд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулсан байна.
- Завхан аймгийн хэмжээнд 129 байгууллагын дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж, 16 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн байна

⁵ Дэлхийн Зөн Монгол ОУБ (ДЗМОУБ), Азийн Сангийн хамтран хэрэгжүүлж байгаа Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлангаас

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Бодлого шийдвэрийн хүрээнд:

- Төрөөс олон талын оролцоог хангасан, нэгдмэл алсын хараатай, үр дүнд суурилсан тодорхой цогц бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна.
- Хүүхэд хамгааллын талаар гаргаж буй бодлого шийдвэр нь салбарт бүрд байгаа ч хэвтээ болон босоо тогтолцооны уялдааг хангаагүй, оролцоог жигд, тэнцвэртэй байдлаар төлөвлөөгүй, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлж чадахгүй, үйлчилгээний стандартын тодорхойгүй байдал нь салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүн төвтэй, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд хэнийг ч орхихгүй байх, хүний суурь эрх, эрх чөлөөг эрхэмлэх, жендерийн мэдрэмжтэй байх зарчимд нийцсэн хүүхдийн эрх, хамгааллын урт, дунд богино хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөртэй болсноор хүүхэд хамгааллын тогтолцоо бэхжихээр байна.

Засаглалын түвшинд:

- Хүүхэд хамгааллын тогтолцооны суурь тавигдсан ч нээлттэй ил тод биш, удирдлагын тогтвор суурьшилтай, хариуцлагатай, хяналттай байдал хангагдахгүй байгаа нь иргэдийн төрд итгэх итгэл үнэмшлийг бууруулж нийгэмд нөлөөлөхүйц эерэг үр дүнг бий болгож чадахгүй байна.
- Хүүхдийн эрх, хамгааллын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хөтөлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай байна.

Үйлчилгээний үр дүнгийн хүрээнд:

- Хамтарсан багийн гишүүд өөрийн үндсэн ажилтай хавсран, цалин урамшуулал, мэргэжил арга зүйн дэмжлэггүй, ажлын ачаалал их, мэргэжлийн бус, хамтарсан багын ахлагч буюу засаг дарга нь улс төрөөс хараат томилгоотой төрийн үйлчилгээний залгамж халаа алдагдсанаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо буурахгүй, үйлчилгээний үр дүнд ахиц гарахгүй байна.
- Гамшиг, онцгой байдлын үед авах арга хэмжээний бэлэн байдал хангагдаж байгаа хэдий ч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн болон эрсдэлд хэдэн хүүхэд өртөж болзошгүй тоо, мэдээлэлгүй байна.
- Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүй, кэйс хаахад илүү анхаарч, хаагдаагүй байгаа кейсийн цаана ямар учир шалтгаан, нөхцөл байгааг нарийвчлан гаргадаггүй орхигдуулж байгаагаас шуурхай, тэгш хүртээмжтэй байдал алдагдаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд түр хамгаалах, нэг цэгийн үйлчилгээ, асрамж халамжийн газарт очиход тухайн хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин, үйлчилгээ байхгүй, ажилтнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадавх байхгүй нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг орхигдуулах эрсдэлтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог тусгай хэрэгцээг харгалзан мэдээллийг хүртээмжтэй түгээж урьдчилан сэргийлэх ажил хийгддэггүй, хүчирхийлэлд өртсөн тохиолдлын бүртгэл мэдээллийг нарийвчлан тусгадаггүй, түр хамгаалах байр, НЦҮТ-д очих тохиолдолд тухайн хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин, нөхцөл бүрдээгүй, ХБХ-тэй ажиллах хүний нөөцийн бэлэн байдал хангагдаагүй нь шуурхай тусламжийн, нөхөн сэргээх кейс менежментийг үе шаттай хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Хяналтын тогтолцоо болон хариуцлагын хүрээнд:

- Хүүхэд хамгааллын салбарт хяналтын тогтолцоо хангалттай бүрдсэн ч хэрэгжүүлэгч байгууллагад дийлэнх ачааллыг хуваарилсан, бодлогын түвшинд хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн төлөө үндэсний болон орон нутаг дахь зөвлөлийн оролцоо байхгүй, нэр төдий байна.
- Салбарын хүрээнд хүний нөөцийн тогтворгүй байдал, төрийн үйлчилгээний залгамж халаа алдагдсанаас хариуцлага хүлээх эзэнгүй болсон байна.
- Хүүхэд хамгааллын салбарт төрийн үйлчилгээг олон талын оролцоо хамтын ажиллагааны хүрээнд шуурхай чанартай хүртээмжтэй хүргэх зорилготой ч холбогдох байгууллагын эрхлэх асуудлын хүрээ, чиг үүрэгтэй нь холбон тодорхойлж чадаагүйгээс хариуцлага хүлээхээс зайлсхийх хандлага бий болсон байна.

- Хүүхэд хамгааллын төсвийн зориулалт, зарцуулалт, үр дүн, үйл ажиллагааны мэдээлэл ил тод биш, төрийн бусад чиг үүргийн байгууллагын хяналт шалгалтад хамрагдах нөхцөлийг бүрдүүлдэггүй, архив албан хэрэг хөтлөлт алдагдсан, дотоод хяналтыг үнэн зөв хийж дүгнэдэггүй байна.
- Олон улсын байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар судалгаа хийх, хандив тусламж өгөх, тайлан мэдээлэл гаргах зэрэг ажилд хувь нэмрээ оруулж байгаа хэдий ч хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хуульд заасны дагуу зөвшөөрөл олгодоггүй, түүнд хяналт тавьж ажилладаггүй байна.
- Хүүхдийн мэдээллийг ашиглах зөвшөөрлийн гэрээ"-нд СОС олон улсын хүүхдийн асрамжийн төвд амьдарч байгаа хүүхэд асран хамгаалагчийн хамт гарын үсэг зурж байгаа нь хүүхдийн хувийн мэдээллийн нууцыг задруулах, ашиглах, хандив тусламж цуглуулах зэрэгт ашиглагдаж байж болзошгүй үйлдэл нь төрөөс олон улсын сайн дурын байгууллагад тавих хяналт байхгүй хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт, судалгаа хийхийг хориглоно гэсэн үндэсний бодлого алдагдсан байна.

Хүүхэд хамгааллын салбарын санхүүгийн болон хүний нөөцийн хүрээнд:

- Хүүхэд хамгааллын салбарт тогтвортой мэргэшсэн хүний нөөц дутмаг, чадавх сул, санхүүгийн болон нийгмийн баталгаа хангагдаагүй нь хүүхэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нэмэгдүүлэх хөшүүрэг болж чадахгүй байна.
- Хөдөө орон нутаг, аймгуудад хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулж буй хамтарсан багийн зардал аймаг тус бүрд харилцан адилгүй, тэнцвэртэй хуваарилж зарцуулагдаагүй, санхүүжилт ямар үр дүнд хүрснийг дүгнэх боломжгүй байгаа нь үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, санхүүжилтийн бодлого байхгүйг харуулж байна.

Хүүхдийн оролцоо, нийгэмшүүлэх тогтолцоо:

- Хүүхэд өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх, өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох боломж, нөхцөл байхгүйгээс хүүхдийн оролцоог хангах тогтолцоо нийгмийн аль ч орчинд бэхжээгүй байна.
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хүүхэд сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжих хугацаанд ар гэрийн орчин нөхцөлийг холбогдох байгууллагуудтай хамтран сайжруулах, суллагдсан хүүхдийг эргэн нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэгт холбогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй боловч хангалттай хэрэгжүүлж чаддаггүй байна.
- Хүүхдийн хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах, тавигдах хяналт байдаггүйн дээр асрамж халамжийн төвд амьдарч байгаа хүүхдээр "Хүүхдийн мэдээллийг ашиглах зөвшөөрлийн гэрээ"-нд асран хамгаалагчаас гадна хүүхдээр өөрөөр нь гарын үсэг зуруулж хувийн хэрэгт хадгалж байгаа асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Мэдээлэл цуглуулалт, хяналт-шинжилгээний найдвартай тогтолцооны хүрээнд:

- Улсын хэмжээнд ХТУ-108 утсанд ирсэн дуудлага мэдээллийг шийдвэрлэх хариу үйлчилгээний программын ашиглалт хангалтгүй, цахилгаан тасарсан үед программ ажиллахгүй, программын эх кодыг ХГБХХГ хүлээж аваагүй хувийн компанид хадгалж байгаа нь системийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй, программ хөгжүүлэлт хийж ашиглалтыг сайжруулах шаардлага үүссэн байна.
- Хүүхэд хамгааллын талаар салбаруудын мэдээлэл цуглуулж байгаа шалгуур үзүүлэлт, аргачлал зөрүүтэйгээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, нотолгоонд суурилсан мэдээллийн удирдлагыг сайжруулах боломжийг хязгаарлаж байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцоог бүхэлд нь хамарсан Хүүхэд хамгааллын мэдээллийн удирдлагын системгүй байгаа нь мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв байдлаар солилцох, хүүхэд хамгааллын мэдээллийг тогтмол хугацаанд цуглуулж, дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээг төлөвлөх эх үүсвэрийг бүрдүүлэх бааз суурийг бэхжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд:

- ХЭК-р хүлээсэн үүргийг үндэсний онцлогт нийцүүлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан хүүхэд хамгааллын үндэсний бодлогын баримт бичгийг хэнийг ч орхихгүй байх, хүний суурь эрх, эрх чөлөөг эрхэмлэх, жендерийн мэдрэмжтэй байх зарчимд нийцүүлэн хүүхдийн эрх, хамгааллын бодлоготой болгоход анхаарч санал боловсруулж ажиллах;
- Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:

- Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээний актыг боловсруулж батлуулах ажлыг эрчимжүүлэх;
- Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтад хяналт тавьж, хариуцлага тооцон төсвийн сахилга батыг нэмэгдүүлэх;
- Магадлан итгэмжилсэн мэргэшсэн байгууллагаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дэмжиж ажиллахад чиглэсэн ажил зохион байгуулах;
- Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутаг дахь хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан баг, хууль зүйн хорооны гишүүдийн ажил үүргийг хуваарьт хүүхэд хамгааллын үйлчилгээний оролцоог нарийвчлан тусгаж хүүхэд хамгааллын үйлчилгээг дэмжих, бэхжүүлэх, хамтын ажиллагааг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах;
- Хуульд заасны дагуу Олон Улсын санхүүгийн дэмжлэгээр хүүхэд хамгаалал хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааг бүртгэлжүүлж, сургалт, тандалт, судалгаа явуулахад төрийн байгууллагын зөвшөөрөл, хяналтыг хэрэгжүүлэх тогтогцоог бүрдүүлэх;
- Олон Улсын гэрээ хэлцэл, конвенцоор хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцох;
- Хүүхэд хамгааллын тогтолцооны бүх хүрээнд хүүхдийн оролцоог хангаж, хүүхдээр дамжуулан нөлөөллийн, урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв байгууллага бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгааллын арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тусгах, яамны ХШҮДАГ хүүхэд хамгааллын асуудлаар үнэлгээ хийх аргачлалуудыг ХГБХХЕГ-тай хамтран боловсруулж мөрдүүлэх.

Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газарт:

- Хүний нөөцийн оновчтой хуваарилалтыг хийж, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод шинжилгээ хийж давхардсан болон орхигдуулсан чиг үүргийг арилгах;
- “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын үнэлгээний бодит байдлыг хянаж, баримт бичгийг хуульд заасан шаардлагад нийцүүлж, тэгш хүртээмжтэй, мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд нээлттэй болгох;
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг тодорхойлох аргачлал, маягыг судалгаанд үндэслэн боловсруулж батлан, аймаг, нийслэлийн ХГБХХГ болон хамтарсан багийн гишүүдэд таниулан мэдүүлэх;
- Хүүхэд хамгааллын төсвийн төслийг тоо мэдээлэлд үндэслэн боловсруулж, орон нутгийн онцлог тохируулж хуваарилах, олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, үр нөлөөг тооцож хэвших;
- Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийн систем, программд аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг арилгах, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг нэмэгдүүлэх боломжоор хангах;
- Хүүхдийн хувийн болон эрүүл мэндийн эмзэг мэдээллийг хадгалах, хамгаалах, дамжуулах, алдагдахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж хэвших;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагааны болон ТББ-тай гэрээлэн гүйцэтгүүлсэн ажлыг шилэн дансанд тогтмол байршуулж ил тод байдлыг хангаж ажиллах;
- Аймаг, Нийслэлийн хэмжээнд байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглалтын хангалтгүй байдлыг сайжруулах ажлыг зохион байгуулах.

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

www.open.audit.mn
www.audit.mn

(+976) 51-261745
(+976) 11-322071

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн